

ТЕЛЕВИЗИЙН ХӨРӨГ НЭВТРҮҮЛЭГТ ХИЙСЭН ХАНДАЛТЫН СУДАЛГАА

С.Бэлгүүнзаяа*

*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн докторант

Түлхүүр үгс: Телевиз, ур чадвар, үзэгчид, уран бүтээлчид, хөрөг нэвтрүүлэг, баримтат кино, контент, судалгаа

Телевизийн хөрөг нэвтрүүлэг нь нийгмийн үзэгдэл, төлөвшил, хандлага болон үзэл санаанд үр дүнтэй басхүү нэлээд хүчтэй нөлөөлж чадах онцгой төрөл билээ. Телевизийн уран бүтээлчид амьдралын бодит байдал, тэндээс цуглуулсан баримт сэлтийг уран сайхны аргаар боловсруулж, мэргэжлийн бүтээл болгон, үзэгчдийн хүртээл болгоход тэрхүү бүтээлийн нөлөөлөл нь тухайн нэвтрүүлгийн агуулга, зорилго, хэлбэр хийцээс шалтгаалан үзэгчдэд алив нэгэн сэтгэгдэл, бодол, бодрол төрүүлж, амьдралын хэв маяг, тогтсон үзэл санаа цаашлаад үнэт зүйлсийг нь өөрчлөхөд ч нөлөөлдөг. Тэгвэл ийм телевизийн онцгой хөтөлбөрийг манай телевизүүд хэр чанартай бүтээж байна вэ, энэ төрлийн нэвтрүүлгийн эрэлт хэрэгцээ зах зээлд бий юу, цаашид хөрөг нэвтрүүлэг бүтээгч, уран бүтээлчид - бие хүн, нийгэм, соёл, шинжлэх ухаан, урлаг уран сайхан, түүх, өв уламжлал хийгээд үндэсний

сэрэхүйд контентоороо хэрхэн нөлөөлж, эерэг хувь нэмрээ оруулах боломжтой вэ гэсэн асуултууд ундарна. Орчин цагийн үзэгч, хүлээн авагчдын телевизийн хөтөлбөр, контентын сонголт улам бүр олширсоор, басхүү бүтээлээс хүлээж буй чанар нь босго өндөр болсоор байгаа нь үнэн. Нэг үгээр хэлэхэд үзэгчдийн контент сонголт ердийн нэгэн хөтөлбөрөөр хязгаарлагдахаа больж, өөрсдийн шалгуур, үнэлэмж, мэдрэмжид нийцсэн контентыг үзэх боломжтой болсон. Өнөөдөр тэгвэл үзэгч хүлээн авагчдын боловсрол дээшилсэн, өөрчлөгдөн хувьсаж буй нийгмийн энэ хэрэгцээ шаардлага телевизийн салбарт тусгалаа олж байгаагийн илрэл нь холимог буюу гибрид /hybrid/ хөтөлбөрүүд юм. Инфотейнмент, эдүтейнмент, информершиал гэсэн нэршил хэдийнээ шинэ сонин сонсогдохоо больж харин агуулга хэлбэрийн хувьд илүү сонин үзүүштэй гэсэн ойлголтыг дагуулах болсон. (Телевизийн сэтгүүл зүй: Түүх, онол, практик, 2018) Энэ ч утгаар телевизийн хөрөг нэвтрүүлэг, баримтат кино, хөрөг найруулал, хөрөг ярилцлага, хөрөг мэдээ, хөрөг зураглал, хөрөглөсөн

ток шоу... гээд холимог шинж агуулгатай, хүний түүхийг өгүүлэх хөрөг нэвтрүүлэг /контентууд/ телевизийн суваг бүрд бий. Энэ төрлийн бүтээлийн уран чадварын асуудлыг мэргэжлийн хүрээнд бид өөр хоорондоо хэлэлцэхээс гадна, үнэн бодит үнэлгээг үзэгч түмнээс бас авах учиртай. Тэгж гэмээнэ бүтээлийн чанар, нэвтрүүлгийн төрөлд юу дутмаг буй нь ажиглагдана. Оросын “НТВ” телевизийн сэтгүүлч, тоймч Леонид Парфенов “Телевизийн нэвтрүүлэгт олон шалгуур үзүүлэлт байхгүй. Ердөө үзэгчид үзэж байна эсвэл үзэхгүй байна гэсэн хоёр шалгууртай. Тэднийг үзүүлэхийн тулд бүх зүйл нь сонирхолтой байх ёстой”

(Г.Мэндхүү, Т.Өнөрсайхан, 2015) гэсэн байдаг. Тиймээс энэхүү судалгааны зорилго нь иргэдийн телевизийн хөрөг нэвтрүүлгийн үзэлт, хандалт, үнэлэмжийг тодорхойлон улмаар телевизийн салбарт энэ төрлийн нэвтрүүлэг хэр эрэлт хэрэгцээтэй байгааг тодруулж, цаашид хөрөг бүтээгчид юунд анхаарах хэрэгтэй вэ гэдэг ерөнхий дүр зураг гарахад оршино. “Үзэгчдийн телевизийн хөрөг нэвтрүүлэг үзэлт, хандалтын судалгаа”-г 2024 оны 10,11-р сард үндэсний хэмжээнд 480 телевиз үзэгчдийг хамруулан явуулсан болно.

Судалгаанд оролцогсдын нас, хүйсийн байдлыг харуулбал:




График №1. Судалгаанд оролцогсдын нас, хүйсийн бүтэц.

Насны бүтцийг авч үзвэл судалгаанд оролцогсдын 15,4 хувь нь 24 хүртэлх насныхан, 23,3 хувь нь 25-34 насныхан, 40,6 хувь нь 35-44 насныхан, 10,8 хувь нь 45-54 насныхан, 9,8 хувь нь 55-аас дээш насныхан байв.

Харин хүйсийн хувьд 41 хувь нь эрэгтэй, 59 хувь нь эмэгтэй байлаа.

Хүснэгт №1-ээр судалгаанд хамрагдагсдын боловсролын түвшин болон хаанаас энэхүү судалгаанд оролцсон байдлыг харуулав.

Боловсролын түвшин	Хувь	Газар зүйн байршил	Хувь
Бага	0,8%	Улаанбаатар хотоос	77,3%
Дунд	9,4%	Хөдөө орон нутгаас	18,1%
Тусгай боловсрол	11,3%	Хилийн чанадаас	4,6%
Дээд	78,5%		

Хүснэгт №1. Респондентуудын боловсролын түвшин, судалгаанд хамрагдалтын газар зүйн байршил.

Судалгаанд оролцогчдын боловсролын түвшинг харвал 0,8 хувь нь бага боловсролтой, 9,4 хувь нь дунд боловсролтой, 11,3 хувь нь тусгай боловсролтой харин 78,5 хувь нь дээд боловсролтой байна. Мөн судалгаанд хамрагдагсдын газар зүйн байршлын хувьд харвал

Улаанбаатар хотоос 77,3 хувь буюу 371 хүн, хөдөө орон нутгаас 18,1 хувь буюу 87 хүн, хилийн чанадаас 4,6 хувь буюу 22 хүн энэхүү судалгаанд хамрагдлаа.

Үзэгчдийн телевизийн хөрөг нэвтрүүлэг үзэлт, хандалтын байдлыг дараах графикаар харуулбал:




График №2. Телевизийн хөрөг нэвтрүүлэгийн үзэлт, хандалт хувиар.

Та телевизийн хөрөг нэвтрүүлэг үзэх дуртай юу? /баримтат хөрөг кино, хөрөг найруулал, хөрөг ярилцлага гэх мэт/ гэсэн асуултад судалгаанд оролцогчдын тэн хагас буюу 52 хувь нь тааралдвал үзчихдэг, 38,3 хувь нь үзэх дуртай, 9,6 хувь нь үзэх дургүй хэмээн хариулжээ. Эндээс харахад хөрөг нэвтрүүлэг бол хүлээн авагчдын хувьд эрэлт хэрэгцээтэй, сонирхол татсан телевизийн контент гэдэг нь үүгээр батлагдаж байна. Түүнчлэн... “Үзэгчид зурагтын өмнө суухдаа юу хүсэж байгаагаа мэддэггүй, суваг сольж тухайн үед анхаарал татсан нэвтрүүлгүүдийг сонгон үздэг. Тиймээс тэдний хүслийг урьдчилан таамаглаж, сонирхлыг нь татах бүтээл хийх ёстой. Үүний тулд

зорилтот бүлгээ судлах, тэдний онцлогийг ойлгож, мэдэх шаардлагатай” гэж Америкийн судлаач Ийстман С.Т, Фергусон Д.А нар “Мэдээллийн хэрэгслийн хөтөлбөр төлөвлөлт: стратеги ба арга зүй” номондоо дурдсан байдаг. (Т.Өнөрсайхан, 2023) Эндээс харахад судалгаанд хамрагдсан респондентууд ч үүнийг мөн баталж талаас илүү хувь нь “тааралдвал үзчихдэг” гэж хариултыг сонгосон нь суваг тохируулахад тааралдсан хөрөг нэвтрүүлэг бүр сонирхолтой, үзүүштэй бас өгөөжтэй байх нь чухлаар тавигдаж байна гэсэн үг. Телевизийн хөрөг нэвтрүүлэг үзэх дуртай бол яагаад гэсэн асуултад респондентууд хэрхэн хариулсныг графикаар үзүүлбэл:




График №3. Хөрөг нэвтрүүлэг үзэх шалтгаан, олон сонголтоот хариулт.

Судалгаанд оролцогчид дээрх асуумжид олон хариулт сонгож оролцсон бөгөөд үр дүнг графикаас харахад 58,3 хувь нь хүний амьдралын түүх сонирхолтой санагддаг учир хөрөг нэвтрүүлэг үзэх дуртай; 40 хувь нь хөрөг баатраас урам зориг, мотиваци, сургамж авдаг; 36.3 хувь хөрөг нэвтрүүлэгт танин мэдэхүйн мэдээлэл их байдаг, 34 хувь нь тус төрлийн нэвтрүүлгээс түүх нийгэм цаг үеийн байдлыг олж мэддэг; 10.8 хувь нь гоо зүй, урлагийн таашаал авдаг гэсэн бол харин судалгаанд оролцогчдын 9.4 хувь нь хөрөг нэвтрүүлэг зүгээр л үзэх дуртай гэж тус, тус хариулсан байна. Эндээс хүмүүсийн сониуч зан улам ихэссэн өнөө цагт хөрөг нэвтрүүлэг үзэх үзэгчдийн хандалт их байна. “Хөрөг нэвтрүүлэг бол хувь хүн, нийгмийн бодит амьдрал, цаг үеийн үйл явдал дээр үндэслэн

бүтээгдэхийн хувьд түүхэн баримт болж үлддэг үнэ цэнтэй телевизийн бүтээл юм. Тиймдээ ч уран бүтээлчдээс ур чадвар, уйгагүй хөдөлмөр, мэдрэмж, мэргэжлийн ёс зүй болоод цаг хугацаа шаарддаг онцгой төрөл зүйл юм” (С.Бэлгүүнзаяа, 2022)

Нөгөө талаас энэ нэвтрүүлгийн төрөл нь хөрөг баатраар дамжуулж хүний нийгмийн сайн сайхныг тольдох, түүнээс үлгэр дуурайл авах, магадгүй алдаанаас нь суралцах, амжилтын нууцыг нь мэдэх гээд танин мэдэхүй, гоо зүй болон хүмүүжил төлөвшил, нөлөөллийн ач холбогдол өндөртэй учир үзэгчид үзэх дуртай нь дээрх үр дүнгээс илэрхий байна.

Харин хөрөг нэвтрүүлгийн гол баатар ямар хүн байвал сонирхолтой санагддаг тухай асуултад үзэгчид хэрхэн хариулсныг харуулбал:




График №4. Хөрөг нэвтрүүлгийн тааламжит гол дүр, олон сонголтоот хариулт.

Хөрөг нэвтрүүлгийн гол баатар эгэл жирийн хүн байвал сонирхолтой гэж 62.3 хувь нь хариулсан бол 50.6 хувь түүхэн аугаа хүмүүс, 29.6 хувь нь урлаг спортын алдартан, 12.9 хувь нь улс төр, бизнесмен, 11.9 хувь нь сошиал нөлөөлөгч, олны танил хүний хөрөг нэвтрүүлгийн баатраар сонговол сонирхолтой гэсэн үр дүн гарчээ. Дэлхий дахинд телевизийн эхэн үе буюу 1940-1950-аад оноос эхлээд хөрөг нэвтрүүлгийн гол баатар урлаг, соёл, спорт, улс төрчид байв. Тэдний үйл хэрэг, гавьяа зүтгэлээр улс орон, нийгэм, хүн зоны ухамсар төлөвшилд нөлөөлөх зорилго бүхий байсан бол

өнөөдөр эгэл жирийн хүний дотоод мөн чанар, амжилт бүтээл, алдаа оноо, оршихуйн тухай түүх өгүүлэх нь ихсэж, үүнийг үзэгчид мөн таашаан үзэх сонирхолтой байна. Энэ нь ч энэхүү асуумжийн үр дүнгээс батлагдаж байна.

Манай телевизүүд хөрөг нэвтрүүлэг, баримтат киног хангалттай сайн бүтээж, олон нийтэд түгээдэг гэвэл та санал нийлэх үү? Түүнчлэн телевизүүд баримтат кино, хөрөг нэвтрүүлэг тогтмол бэлтгэж, олон нийтэд үзүүлэх шаардлагатай юу? гэсэн асуултуудад үзэгчид хэрхэн хариулсныг графикаар харуулбал:





График №5. Телевизүүдийн хөрөг нэвтрүүлгийн бүтээмж ба энэ төрлийн нэвтрүүлгийн эрэл хэрэгцээ.

Монголын телевизүүдийн хөтөлбөрт хөрөг нэвтрүүлэг хангалтгүй байдаг гэж судалгаанд оролцогчдын 58.8 хувь нь үзсэн бол 29.4 хувь манай телевизүүд хөрөг нэвтрүүлгийг хангалттай сайн хийж түгээдэг гэж хариулсан байна. Харин 11.9 хувь нь үзэх нэвтрүүлэг огт олдоггүй гэж хариулжээ. Үзэх нэвтрүүлэг огт олдоггүй гэдэг хариулт нь үзэхээр, сонирхол татахаар чанартай хөрөг нэвтрүүлэг телевизүүдэд байхгүй байна гэдэг утга санаа агуулагдаж байгаа нь харагдаж байна. Тэгвэл

энэ төрлийн нэвтрүүлэг телевизүүд бэлтгэх ба үзэгчид хүлээн авах хэрэгцээ шаардлага хэр байна вэ гэдэг асуумжид нэн шаардлагатай гэж үзсэн 18.3 хувь, шаардлагатай гэж үзсэн 78.8 хувь, огт шаардлагагүй гэж хариулсан 2.9 хувь байна. Дээрх хоёр асуумжаас харахад мэдээллийн багтаамж сайтай, чанартай хөрөг нэвтрүүлэг манай телевизүүд тогтмол бүтээж нийлүүлэх шаардлагатай дээр үзэгчид ч энэ төрлийн нэвтрүүлгийг үзэж, сонирхох хэрэгцээ өндөр байна.

Тэгвэл телевизүүдийн бэлтгэн хүргэж буй хөрөг нэвтрүүлгүүдийн нийтлэг дутагдалтай талыг нэрлэнэ үү гэсэн олон сонголтод хариулттай

асуумжид судалгаанд хамрагдагсад хэрхэн харуулсныг график №6-гаас харвал:




График №6. Телевизийн хөрөг нэвтрүүлгүүдийн нийтлэг дутагдалтай талууд, олон сонголтот хариулт.

Судалгаанд оролцогчдын 46.9 хувь нь манай телевизүүдийн хөрөг нэвтрүүлэг дан магтаал агуулсан шинжтэй байдаг гэж үзсэн бол 39.6 хувь нь агуулга ядмаг, хэлбэр давамгайлсан хөрөг нэвтрүүлэг нийтлэг байна гэж хариулжээ. Түүнчлэн судалгаанд оролцогчдын 33.5 хувь нь телевизийн хөрөг нэвтрүүлгийн мэдээллийн багтаамж ядмаг байгааг тодотгосон бол сэтгүүлч, хөтлөгчийн уран чадвар сул гэж 28.1 хувь нь, зохиол тайлбар муутай гэж 27.7 хувь нь, найруулга, зураг авалт тааруу гэж 19.8 хувь нь үзжээ. Эндээс харахад асуумжид тусгагдсан өнөөгийн хөрөг нэвтрүүлгүүдэд байх магадлал бүхий дутагдалт талуудыг үзэгчид олон сонгол-

тоор ихэнхийг нь сонгосон байгаа нь графикаас харагдаж байна. “Орчин үеийн “сонголт ихтэй үзэгчид” хоосон хэлбэр, эсвэл уйтгартай хэт их мэдээллийг телевизээр хүлээн авах сонирхолгүй байна. Тэд телевизээс илүү эхийг буюу анхдагч төрлийн агуулга, хэлбэрээс ахисан шатыг шаардах болжээ (Телевизийн сэтгүүл зүй: Түүх, онол, практик, 2018). Иймээс манай хөрөг бүтээгчид цаашид хөрөг нэвтрүүлгийн дээрх дутагдалт талууд дээр илүүтэй анхаарч ажиллах шаардлагатай байна.

Үзэгчдийн үзэх дуртай телевизийн хөрөг нэвтрүүлгийн асуумжид судалгаанд оролцогчид дараах байдлаар хариулсан байна.

Нэвтрүүлгийн нэр	Телевиз /студи, продакшн/	Хувь
“Гэгээн үдэш” хөрөг нэвтрүүлэг	МУОНТ	19.2%
“Монгол тулгатны зуун эрхэм” хөрөг ярилцлага	Hero entertainment, Б.Баатар	65.8%
“Хэн нэгэн” иргэний хөрөг	Түлхүүр студи	9.6%
“Зогсошгүй” хөрөг нэвтрүүлэг	МУОНТ	6.9%
“Би” хөрөг ярилцлага	25-р суваг телевиз	21.3%

“Болзоо” хөрөг ярилцлага	NTV телевиз	23,3%
“Амьдралын загвар” хөрөг нэвтрүүлэг	МҮОНТ	16.9%
“Алганы хээ” хөрөг ярилцлага	С1 телевиз	18.5%
“Энэ миний амьдрал” хөрөг нэвтрүүлэг	25 телевиз	16.3%
“Танил хүн” хөрөг ярилцлага	ТМ телевиз	12.3%
“Бидний нэг” хөрөг ярилцлага	Тойм.мн	2.7%
“Хүний түүх” хөрөг ярилцлага	NTV телевиз нь	3.8%
“Миний түүх” хөрөг нэвтрүүлэг	“Эх орон” телевиз	4.6%
“17 нас” хөрөг ярилцлага	Боловсрол суваг телевиз	8.1%
“Түмний нэг” хөрөг ярилцлага	MNC телевиз	7.9%
“Тэр” хөрөг нэвтрүүлэг	Монгол HD телевиз	1.5%
“Эгэл нэгэн хөрөг” нэвтрүүлэг	Cchannel TV	2.7%
“Миний мэргэжил” хөрөг нэвтрүүлэг	Боловсрол суваг телевиз	11.3%
“Монгол товчоон” хөрөг ярилцлага	Монгол кино пикчрес, П.Анужин	7.7%
“Гэргий” хөрөг ярилцлага	Амьдрал фильм, Л.Мөнхбаясгалан	25.8%
“Би Монгол хүн” хөрөг нэвтрүүлэг	МҮОНТ	15%
Бусад		15.8%

Хүснэгт №2. Үзэгчдийн үзэх дуртай хөрөг нэвтрүүлэг, олон сонголтот хариулт.

Таны үзэх дуртай телевизийн хөрөг нэвтрүүлгүүд гэсэн олон сонголтот хариулттай асуумжид санал ихээр авсан нэвтрүүлгүүдийг дурдвал, үзэгчдийн дийлэнх буюу 65.8 хувь нь Херо энтертаймент студи, Б.Баатар найруулагчийн “Монгол тулгатны зуун эрхэм” хөрөг нэвтрүүлгийг үзэх дуртай гэж хариулсан бол Амьдрал фильм студи, сэтгүүлч Л.Мөнхбаясгалангийн “Гэргий” хөрөг нэвтрүүлгийг 25.8 хувь, NTV телевизийн “Болзоо” хөрөг ярилцлагыг 23.3 хувь, 25-р суваг телевизийн “Би” хөрөг ярилцлагыг 21.3 хувь, МҮОНТ-ийн “Гэгээн үдэш” хөрөг нэвтрүүлгийг 19.2 хувь, С1 телевизийн “Алганы

хээ” хөрөг ярилцлагыг 18.5 хувь, МҮОНТ-ийн “Амьдралын загвар” хөрөг нэвтрүүлгийг 16.9 хувь, 25-р суваг телевизийн “Энэ миний амьдрал” хөрөг нэвтрүүлгийг 16.3 хувь үзэх дуртай гэж хариулжээ. Түүнчлэн асуумжид орсон телевизүүдийн бусад нэвтрүүлгүүд тодорхой хэмжээний /1,5-15,8 хувь/ үзэгчидтэй байгаа нь хүснэгтээс харагдаж байна.

Судалгаанд оролцогчдоос таны сонгож үздэг хөрөг нэвтрүүлгийн юу нь танд таалагддаг вэ гэсэн асуултад дараах байдлаар хариулсан байна.




График №7. Үзэгчдийн үзэх дуртай хөрөг нэвтрүүлгийн онцлог талууд, олон сонголт.

Өмнөх асуумжид рейтинг өндөртэй гарсан телевизийн хөрөг нэвтрүүлгүүдийн чухам юу нь таалагддаг учраас сонгож үзэж байна гэсэн олон сонголт бүхий асуултад үзэгчдийн 49.2 хувь нь хөрөг баатар, дүр нь сонирхолтой байдаг учраас, 40.8 хувь нь зураг авалт, найруулга сайтай болохоор, 36.7 хувь нь хөрөг баатраар дамжуулж буй сэдэв, түүх сонирхолтой учраас, 35.6 хувь нь сэтгүүлч, хөтлөгч нь чадварлаг учраас үзэх дуртай байдаг гэж хариулсан бол судалгаанд хамрагдагсдын 11.7 хувь хүмүүс их үздэг болохоор дагаж үздэг гэж идэвхгүй үзэгчдийн байрнаас

хариулсан байна. Энэ асуумжийн дүнг товч дүгнэхэд хөрөг бүтээгч, телевизийн уран бүтээлчид сонирхолтой хөрөг баатар, нийгмийн дүр үзэгдлийг сонгох, түүгээр дамжуулж түүх өгүүлэх, нийгэмд нөлөөлөх мөн зураг авалт найруулга, уран бүтээлчдийн уран чадвар дээр анхаарч ажиллавал үзэгчдийн таашаалд нийцсэн бүтээл гаргаж, эрэл хэрэгцээтэй байх бүрэн боломжтой нь харагдаж байна.

Судалгааны сүүлчийн асуумж буюу хөрөг нэвтрүүлэг ямар төрлөөр хийгдсэн байвал та илүүд үзэх вэ гэсэн асуултад хэрхэн респондентууд хариулсныг харуулбал:



График №8. Телевизийн хөрөг нэвтрүүлгийн дуртай хэлбэр, төрөл.

Хөрөг нэвтрүүлэг ямар төрлөөр хийгдсэн байвал та илүүд үзэх вэ гэсэн асуумжид үзэгчдийн 46.7 хувь нь Баримтат кино хэлбэрээр буюу түүх, нийгэм цаг үеийн баримтаар баяжуулж, кино хөрөг хэлбэрээр хийгдсэн байвал илүүд үзнэ гэсэн бол 39.2 хувь нь хөрөг ярилцлагаар буюу сэтгүүлч хөтлөгчтэй хүүрнэн ярилцсан, эсвэл ярилцлагын ток шоу хэлбэртэй хийгдсэн байвал дуртай гэсэн байна. Харин 14.2 хувь нь уран сайхны аргаар зохиомжилж хийгдсэн, уран яруу тайлбар өгүүлэмжтэй хөрөг найруулал

хэлбэрээр хийгдсэн байвал үзэхэд таатай гэжээ. Ер нь хөрөг нэвтрүүлэг анх телевизийн хөтөл-бөрт орж ирэхдээ кино мэдээ, баримтат кино чиглэлээр эхэлсэн. Цааш хөгжлийн явцад илүү ярилц-лагын хэлбэрт шилжсэн. Гэтэл баримтат кино хэлбэрээр хөрөг нэвтрүүлгийг бүтээх нь бүтээл, баримт хадгалагдан үлдэх, үзэгчдэд өгч байгаа өгөөжийн хувьд ч үнэ цэн ихтэй гэдгийг үзэгчдийн хариултаас бид харж байна. Дүгнэлт:

- Телевизийн хөрөг нэвтрүүлэг, баримтат киног үзэгчид үзэх дур-

тай, энэ төрлийн нэвтрүүлэг телевизийн хөтөлбөрт эрэлт хэрэгцээтэй, цаашид зайлшгүй байх шаардлагатай нь үзэгчдээс авсан судалгааны дүнгээс харагдаж байна.

- Үзэгчдэд хүний амьдралын түүх сонирхолтой санагддаг мөн хөрөг нэвтрүүлгийн баатраас урам зориг, сургамж авдаг учраас энэ төрлийн нэвтрүүлгийг үзэх дуртай гэжээ. Ингэхдээ улс төр, урлаг соёлын алдартнуудаас илүү эгэл жирийн хүний түүх эсвэл түүхэн аугаа хүмүүсийн баримтат киног үзэгчид илүүтэй үзэхийг хүсэж байна. Тиймээс дүрийн сонголт оновчтой байхаас гадна хөрөг баатраар дамжуулж хүргэх санаагаа тод томруун байлгаж, нэвтрүүлгийн мэдээллийн багтаамжаа уран бүтээлчид чанаржуулах шаардлагатай байна.
- Манай телевизийн хөрөг нэвтрүүлгүүд дан магтаал агуулсан, агуулга ядмаг, хэлбэр давамгайлсан хийцтэй мөн сэтгүүлч, хөтөлгчийн уран чадвар нь сул байдаг гэж үзэгчид тодорхойлсон байна.
- Үзэгчдийн үзэх дуртай хөрөг нэвтрүүлгээр Херо энтертаймент студи, Б.Баатар найруулагчийн “Монгол тулгатны зуун эрхэм” нэвтрүүлэг олонх саналыг авсан нь тус нэвтрүүлгийн хэлбэр, хийц найруулга шийдэл, дүр сонголт үзэгчдийн таашаалд нийцэж байгааг харуулж байна. Гэвч тус контент телевизээр цацагддаг ч хувийн студи, продакшны бүтээл гэдгийг онцлох хэрэгтэй.

- Эцэст нь дүгнэхэд манай телевизүүд уран бүтээлчдийнхээ ур чадварыг нэмэгдүүлж, чанартай бүтээл хийхэд нь цаг хугацаа, тоног төхөөрөмж, цалин хангамжийг нь нэмэгдүүлж, бодлогоор дэмжих шаардлагатай байна.

Эшлэл

1. МУИС, Сэтгүүл зүй олон нийтийн харилцааны тэнхим (2018). Телевизийн сэтгүүл зүй: Түүх, онол, практик. УБ.
2. Мэндхүү.Г, Өнөрсайхан.Т (2015). Мэргэжлийн телевиз. УБ.
3. Өнөрсайхан.Т (2023). Телевизийн бүтээлийн формат: Шинэ хандлага, холимог хувилбарууд. Сэтгүүл зүй сэтгүүл ЭШБ №24. УБ.
4. Бэлгүүнзаяа.С (2022). “Телевизийн хөрөг нэвтрүүлгийн уран чадварын зарим асуудалд”. Сэтгүүл зүй сэтгүүл ЭШБ №23. УБ.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. МУИС, Сэтгүүл зүй олон нийтийн харилцааны тэнхим (2018). Телевизийн сэтгүүл зүй: Түүх, онол, практик. УБ.
2. Зулъякафиль М. Сэтгүүл зүйн тайлбар толь. (2018). УБ.
3. Банзрагч М. Сэтгүүлчийн хөдөлмөр. (2006). УБ
4. Мэндхүү.Г, Өнөрсайхан.Т (2015). Мэргэжлийн телевиз.УБ.
5. Бэлгүүнзаяа.С (2022). “Телевизийн хөрөг нэвтрүүлгийн уран чадварын зарим асуудалд”. Сэтгүүл зүйн магистрын зэрэг горилсон бүтээл. УБ.

Summary

The purpose of this study is to determine the views, attitudes, and values of television portrait programs among citizens, clarify the demand for this type of program in the television industry, and get

a general picture of what portrait creators should pay attention. The viewer's television watching and access survey was conducted in October and November 2024,

covering 480 television viewers at the national level.

Keywords: Television, skills, audience, portrait programme, portrait interview, documentary, research.